



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/1443

Номгон

г Орог нуур, Түйн гол түүний цутгал голуудыг
биологийн төрөл зүйлийн судалгаа хийлгэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орог нуур, Түйн гол түүний цутгал голуудын биологийн төрөл зүйлийн судалгаа хийлгэх ажлыг 2023 оны 08 дугаар сарын 14-нөөс 2023 оны 10 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Орог нуур, Түйн гол түүний цутгал голуудын биологийн төрөл зүйлийн судалгаа хийлгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай

3.Дээрх судалгааг хийлгэхэд шаардагдах 10.500.000 (Арван сая таван зуун мянган) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

4.Орог нуур, Түйн гол түүний цутгал голуудын биологийн төрөл зүйлийн судалгаа хийлгэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар ханган холбогдох тайлан, үр дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Б.Ням-очир)-д үүрэг болгосугай.

5.Захирамжид хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

842311135

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын
.14...-ний өдрийн 1143 дугаар захирамжийн
хавсралт

ОРОГ НУУР, ТҮЙН ГОЛ ТҮҮНИЙ ЦУТГАЛ ГОЛУУДЫН
БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН СУДАЛГАА ХИЙЛГЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	
Б.Ням-очир	Бөөнцагаан – Орог нуурын сав газрын захиргааны дарга
Гишүүн:	
Г.Нансалмаа	Бөөнцагаан – Орог нуурын сав газрын захиргааны Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Ш.Энхбилэг	Байгаль орчин аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн
Ш.Бат-очир	Бөөнцагаан – Орог нуурын сав газрын захиргааны Нуурын экосистемийн үнэлгээ, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	
Л.Энхтогтох	Усны чанар экологи, үнэ төлбөр хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____